

DPUB2
Монгол Улс
дахь ХБИ-ийн
хөдөлмөр
эрхлэлтийг
дэмжих
тогтолцоог
бэхжүүлэх
төсөл

DPUB 2 МЭДЭЭ

№ 01
2022 оны Нэгдүгээр сар

1. Дуня компани байгуулагдсан цагаасаа хойш Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажил хөдөлмөр эрхлэх боломж олгож байна




DPUB2 төсөл ХБИ-ийг ажиллуулж буй ААНБ-уудаар зочлон уулзалт ярилцлага хийж байгаа юм. Энэхүү ажлын хүрээнд 11-р сарын сүүлээр Улаанбаатар хотын төвөөс нэг цаг орчмын зайтай үйлдвэрийн бүсэд байрлах Дуня мебель ХХК-аар зочиллоо.

Тус компанийг 1998 онд модон эдлэлийн чиглэлээр үйлдвэрлэл эрхлэх зорилгоор Турк, Монгол гэр бүлийн хосууд үүсгэн байгуулжээ. Хувь хэрэглэгч болон

ХНХЯ зэрэг олон төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж, бүх төрлийн модон эдлэл, гэр ахуйн тавилга, гадна доторх хаалга, цонх үйлдвэрлэдэг байна.

Захирал Алтунтас “Ажилгүй гэртээ байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нийгэмд гарч ажиллах боломж олгох” чин хүсэл тээсээр компаниа байгуулснаас хойш ХБИ-ийг ажиллуулж байна. Тэрээр Хөгжлийн бэрхшээлтэй ажилчин нэг бүртэйгээ ганцаарчлан уулзаж, мэдэхгүй чадахгүй зүйлийг нь зааж зөвлөн анхаарал тавьдаг байна. Эхнэр /дэд захирал / Нямбуу “Манай 20 гаруй ажилтны дийлэнх нь анх компаниа байгуулагдсан цагаас ажиллаж ирсэн, бид нэг гэр бүл мэт ойр дотно байдаг” хэмээн инээмсэглэн ярьж байлаа.



Хөнгөн хэлбэрийн саажилт болон хэл ярианы хавсарсан бэрхшээлтэй Гандуулга нь сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвд мужааны мэргэжил эзэмшиж, тус компанид дадлага хийх үедээ хичээнгүйлэн сайн ажиллаж, 2007 оноос өнөөдрийг хүртэл үндсэн ажилтнаар ажиллаж байна. “Өмнө нь өөрийгөө юу ч хийж чадахгүй гэж голдог байсан ч Дуня мебель ХХК-тай ажилд орсны дараа өөрийнхөө хүсэл сонирхол, чаддаг зүйлийг мэддэг болсон” хэмээж байлаа. “Миний хамгийн сайн хийж чаддаг зүйл бол цонхны хүрээ” хэмээн итгэл дүүрэн, нүүр бардам инээмсэглэн ярих Гандуулгын царай гэрэлтэж байв.

Цэвэр модны үнэр, ажилчдын эрч хүч, хамт олны халуун дулаан уур амьсгалаар бялхаж байна.

СЭДЭВ

1
Дуня компани байгуулагдсан цагаасаа хойш ХБИ-д ажил хөдөлмөр эрхлэх боломж олгож байна

2
Инстаграмын инфлюенсер Билэгсайхантай уулзсан тэмдэглэл

3
ДЕТ Форумын тэргүүн Б. Энхням “Хөгжлийн бэрхшээл хүндээ бус нийгэмдээ байдаг”

DPUB2

Монгол Улс
дахь ХБИ-ийн
хөдөлмөр
эрхлэлтийг
дэмжих
тогтолцоог
бэхжүүлэх
төсөл

2. Инстаграмын инфлюенсер Билэгсайхантай уулзсан тэмдэглэл

DPUB2 төслийн олон нийттэй харилцах ажилчид инфлюенсер Билэгсайхантай /Сайханаа/ уулзлаа.

Сайханаа төрөлхийн тархины саажилттай ба өөрийн хүсэл сонирхолдоо хөтлөгдөн 2019 оноос Монгол залуучууддаа эерэг хандлага түгээх зорилгоор инстаграм хуудас идэвхтэй хөтөлж, өдгөө 17,000 гаруй дагагчтай болжээ. Тэрээр өрөөгөө цэвэрлэх, найзуудтайгаа гадуур гарах, хийж буй ажлынхаа талаар зураг бичлэгээр нийтэлдэг бөгөөд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг өрөвдөж тусгайлан хандахгүй байгаарай, бид бүгд л адилхан шүү” гэсэн санааг өдөр тутмынхаа амьдралаар дамжуулан хүргэдэг юм.



“Намайг хөгжлийн бэрхшээлтэй гэж ялгалгүй ах, эгч нарын минь адилаар энгийн хүүхэд шиг өсгөж хүмүүжүүлсэн эцэг эхийнхээ ачаар би бүх зүйлд талархаж, өөдрөг үзэлтэй болсон” гэж ярих Сайханаа маань бусад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хүнд хэцүүг туулж яваа хүмүүст урам зориг өгөхийг зорьж өөрийн бүх постоор дамжуулан эерэг хандлага түгээсээр байна.

Сайханаа амралтын өдрүүдээр магистарт суралцаж, мэдээлэл харилцаа холбоо, инженер, дэд бүтэц, үл хөдлөх хөрөнгө, уул уурхай, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний салбарт үйл ажиллагаа явуулдаг Монголын томоохон компани MCS группт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх орчны талаарх судалгаа болон зөвлөмж боловсруулах албанд эрч хүч дүүрэн ажиллаж байна.

Бидний зүгээс ч мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ААНБ-уудад нөлөөлөх ажил дээр хөдөлмөрч, хичээнгүй Сайханаатай хамтарч ажиллах хүсэлтэй байна.



3. DET Форум Монгол ТББ-ын тэргүүн Б. Энхням “Хөгжлийн бэрхшээл хүндээ бус нийгэмдээ байдаг”

Бид “DET Форум Монгол” ТББ-ын тэргүүн Б.Энхнямын гэрт зочиллоо.

“DET Форум Монгол” нь хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй байхаас үл шалтгаалан хувь хүн бүрийн онцлогийг хүлээн зөвшөөрсөн хамтын нийгмийг бий болгох зорилготой бөгөөд багийн хэлэлцүүлэг хийх хэлбэрээр харилцан суралцах сургалтыг Монголдоо түгээн таниулж буй байгууллага юм.



Багадаа халдварт саа өвчнөөр өвдөж, хөдөлгөөний бэрхшээлтэй болсон Энхням маань DET сургалтаар дамжуулан DPUB1 төсөлтэй учирсан юм. Тэрээр өмнө нь ХБИ-д нийгмийн амьдралд оролцохын тулд өөрсдөө л хичээх ёстой гэж боддог байсан бол DET сургалтад хамрагдсанаар “Хөгжлийн бэрхшээл хүндээ бус нийгэмдээ байдаг бөгөөд үүнийг арилгахын тулд хүн бүр хамтдаа хичээх ёстой” гэх “Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар”-ын үзэл баримтлалаас ихийг сурч мэджээ. Энэхүү үзэл баримтлалыг Монголд түгээн дэлгэрүүлэхээр зориг шулуудан сургагч багшийн сургалтад хамрагдаж улмаар 2017 онд нөхдийн хамтаар “DET Форум Монгол” ТББ-ыг байгуулсан юм.



ТББ-аа удирдахын хажуугаар зэс, алтны уул уурхайн олборлолт явуулдаг Оюу толгой компаний төв оффист 2021 оны зунаас ажиллаж байна. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил хөдөлмөр эрхэлснээр өөрсдийн дуу хоолойгоо нийгэмд хүргэх боломж нээгдэнэ” гэж ярих нь нэгийг бодогдуулав. Өдгөө хамт ажиллаж буй Номин “Энхнямыг манайд ажилд орсноос хойш ажлын өрөөний усны сав хэтэрхий өндөрт байралсаныг байнга явж өнгөрдөг зам

хүртээмжгүй болохыг анзаарч эхэлсэн” хэмээн ярьж байлаа.

Япон улсын туршлагаас суралцсан залуус Монголын нийгэмд өөрчлөлтийг авчирч салбар бүрд хичээн ажиллаж буйд туйлын баяртай байна. Бид цаашид ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллаж буй ААНБ-уудын сайн жишээг нийтэд түгээн танилцуулах болно.

✉ dpub.jica@gmail.com

📍 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж-5 Улаанбаатар-15160

📘 <https://www.facebook.com/jicadpub1and2>

🌐 <https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>

